



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 2.

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг шинээр сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2, 77.4 дэх заалтуудыг удирдлага болгон 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Мон Бийф” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.
 1. Цагаачийн Оюунцэцэг
 2. Цагаачийн Цэцэнхүү
 3. Жанцанхорлоогийн Барсболд
 4. Жавзандолгорын Оюунчимэг
 5. Энхтөрийн Пүрэвлхам
 6. Очирбатын Доржханд
2. “Мон Бийф” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.
 1. Дамбачүлтэмийн Байлийхүү
 2. Дашийн Наранцэцэг
 3. Эрдэнэцогтын Төмөртогтох
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг гарсан даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
4. Тогтоолын 1 болон 2 дахь хэсэгт тус тус заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд шинээр томилогдсонтой холбогдуулан компанийн өмнөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ж.Барсболд, Ц.Оюунцэцэг нарыг үргэлжлүүлэн томилсугай.

5. Тогтоолын 1 болон 2 дахь хэсэгт тус тус заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд шинээр томилогдсонтой холбогдуулан компанийн өмнөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн И.Баттуяагийн бүрэн эрхийг 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс дуусгавар болгосугай.
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд нь гишүүний үүргээ хууль болон компанийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх, компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж, шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг гарсан даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБИЛЭГТ



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 1.

Улаанбаатар хот

Компанийн дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтуудыг удирдлага болгон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Мон Бийф” ХК-ийн шинэчилсэн дүрмийг Хавсралт № 1-р баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт зааснаар компанийн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас шинэчлэн баталсантай холбогдуулан “Мон Бийф” ХХК-ийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналын дагуу компанийн дүрмийн төслийн 4.2 дахь хэсгийн “хаалттай” гэснийг, 4.10.1 дэх хэсгийг тус тус хассугай.
4. Энэхүү шийдвэрийн 2 дахь хэсэгт заасан өөрчлөлтийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газарт бүртгүүлэх, шаардлагатай материалыг бүрдүүлэн өгөх, хүлээн авах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг тус компанийн хуулийн зөвлөх Мөнхбаяр овогтой Номинчулуу /РД: КЮ95081405/-нд итгэмжилсүгэй.
5. Компанийн шинэчилсэн дүрэм болон хэлбэр өөрчлөгдсөн тухай бүртгэлийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газарт бүртгүүлсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

С.САЙНБИЛЭГТ